

**УВС АЙМГИЙН ӨЛГИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Огноо:2023.08.08

**ӨЛГИЙ СУМЫН ӨВС, ТЭЖЭЭЛИЙН НӨӨЦ БҮРДҮҮЛЭХ ТЕНДЕРИЙНҮНИЙН САНАЛ  
АВАХ БАРИМТ БИЧИГ**

**Төслийн нэр: ӨЛГИЙ СУМЫН ӨВС, ТЭЖЭЭЛИЙН НӨӨЦ БҮРДҮҮЛЭХ**

**Төслийн дугаар: УВАӨЛСЗДТГ/202312006**

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

**Увс аймгийн Өлгий сумын Засаг даргын тамгын газар** нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **ӨЛГИЙ СУМЫН ӨВС, ТЭЖЭЭЛИЙН НӨӨЦ БҮРДҮҮЛЭХ** тендерт үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2023 оны 09 дүгээр сарын 07- ны өдрийн 10 цаг 00 минут (орон нутгийн цагаар 9 цаг 00 минут)**-аас өмнө [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2023 оны 09 дүгээр сарын 07- ны өдрийн 10 цаг 55 минут (орон нутгийн цагаар 09 цаг 55 минут)**- т нээнэ.

Дотоодны давуу эрх тооцохэсэх.<sup>1</sup> “Тооцно”

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Увс аймгийн Өлгий сумын Засаг даргын тамгын газрын байр, 108 тоот, Утас: 8925-8913, И-мэйл хаяг: [ohinoo\\_1206@yahoo.com](mailto:ohinoo_1206@yahoo.com)**

- 
- 1 Захиалагч тендер шалгаруулалтад давуу эрхийн зөрүү хэрэглэхгүй бол, энэ өгүүлбэрийг хасч оронд нь “Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү тооцохгүй” гэж бичнэ.

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. **Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**
  - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. **Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
  - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
  - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
  - 2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
3. **Тендерийн иж бүрдэл**
  - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
    - (а) Үнийн санал;
    - (б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
    - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
    - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
    - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
4. **Тогтмол үнэ**
  - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
5. **Техникийн тодорхойлол тба арилжааны нөхцөлүүд**
  - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
  - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
6. **Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
  - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Сүүлийн [2] жилийн санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулж ирүүлэх; Сүүлийн [2] жилийн туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн акт хавсаргах /;</p> <p>Бусад нэмэлт шаардлага;</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Харилцагч бүх банкны тодорхойлолт / хугацаа хэтэрсэн өргүй байх/</li> <li>2. Шүүхийн тодорхойлолт / сүүлийн 3 жилд иргэний болон захиргааны хэрэгт хариуцагчаар оролцоогүй байх /</li> <li>3. Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Татварын тодорхойлолт ирүүлэх шаардлагагүй ба Татварын ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас тендер нээсэн өдрийн байдлаар мэдээллийг шалгана.</li> <li>4. Техникийн тодорхойлолтоос зөрвөл татгалзах үндэслэл болно.</li> <li>5. Нийлүүлэх барааг бодит зургаар ирүүлэх /Хүчин чадал үзүүлэлтийг захиалагчийн техникийн тодорхойлолттой харьцуулсан байдлаар/</li> <li>6. Бараа нийлүүлэлтийн хуваарь ирүүлэх /нийлүүлэх хугацааг шалгуур үзүүлэлтэд харгалзана/</li> <li>7. Үнийн саналын ТШМ-1 маягтын дагуу үнийн санал ирүүлэх,</li> <li>8. Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ, хугацаанд багтаан техникийн тодорхойлолт, техникийн нөхцлийн дагуу чанарын өндөр түвшинд нийлүүлж, ашиглалтад хүлээлгэн өгөх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ.</li> <li>9. Сүүлийн 3 жилд хийж гүйцэтгэсэн ижил төстэй ажил нь төсөвт өртгийн 100 хувиас багагүй байх.</li> <li>10. Сүүлийн 3 жил буюу 2020, 2021, 2022 оны борлуулалтын орлого нь төсөвт өртгийн 100 хувиас багагүй байх.</li> <li>11. Гэрээг гүйцэтгэхэд эргэлтийн хөрөнгө хүрэлцээтэй эсэхийг нотлох баримт бичиг /Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө, санхүүгийн бусад эх үүсвэр болон авах боломжтой зээлийн нийт дүн нь гэрээний үнийн дүнгийн 100%-иас багагүй буюу 30,000,000 /Гучин сая/ төгрөгөөс багагүй байна.</li> </ol> <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар / эх хувиас/,</li> </ol>

<p><b>ТӨӨ32.1</b></p>	<p><b>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</b>  Тендерийн материалыг цахим худалдан авах ажиллагааны системийг ашиглан (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>) хаягаар өөрийн аж ахуйн нэгжийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтрэх ба “Эрүүл мэндийн төвийг шүдний тоног төхөөрөмжтэй болгох” тендерт нийлүүлэгчийг сонгон шалгаруулах, <b>УВАӨЛСЗДТГ/202312006</b>“ дугаар бүхий тендерийг сонгож 50,000 төгрөгийг цахимаар төлсний дараа (pdf)-ээр илгээнэ. Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ 100 Мв, нэг файлын хэмжээ 15Мв байна.</p> <p>Огноо: <b>2023 оны 09 дүгээр сарын 07 -ны өдөр</b></p> <p>Цаг: <b>10 цаг 00 минут (орон нутгийн цагаар 9 цаг 00 минут)</b></p>
<p><b>ТӨӨ32.1</b></p>	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <b>Увс аймгийн Өлгий сумын Нутгийн удирдлагын ордон, 108 тоот.</b></p> <p>Огноо: <b>2023 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>11 цаг 55 минут (Орон нутгийн цагаар 10 цаг 55 минут)</b></p>
<p><b>ТӨӨ32.3</b></p>	<p>Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li><b>1. Тендерт оролцогч хуулийн этгээдийг төлөөлж гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэл ирүүлэх</b></li> <li><b>2. Гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл буюу 5,6-р бүлгийг хүлээн зөвшөөрсөн эсэх мэдэгдлийг ирүүлэх</b></li> </ol>
<p><b>ТӨӨ36.2</b></p>	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>“Багцгүй”</b></p>



1. **Бараа хүргэх газар:** Техникийн тодорхойлолтод нийцсэн эсвэл түүнтэй дүйцэхүйц стандартын шаардлага хангасан тоног төхөөрөмжийг **Увс аймгийн Өлгий сумын Засаг даргын тамгын газарт 10 дугаар сарын 20-ны дотор нийлүүлэх;**
2. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

**БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ**

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-Д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх хэцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

**1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэхбаримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад

нөхцөл: Тендерт оролцогчийн

нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖБУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших  
1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт  
2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
3. Оюуны өмчийн эрх  
3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх  
4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
5. Баталгаат засвары нхугацаа  
5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа **[моо]** жил байна.
6. Гэрээнд өөрчлөлт оруулах  
6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийгөөрчлөхгүй.
7. Төлбөр  
7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш **[ГТН-д заасан моо]** хоногийн дотор шуурхай хийнэ.
8. Бараа нийлүүлэх хуваарь  
8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасанбараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
9. Алданги оногдуулах  
9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах  
10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
11. Маргааныг шийдвэрлэх  
11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1)
- 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)
- 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийгзаасан нэхэмжлэхийн хувь;
  - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийнбаримт;
  - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
  - 4) үйлдвэрийн буюуэрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
  - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5)
- 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
4. Төлбөр (ГЕН – 7)
- 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаардэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн **[moo]<sup>2</sup>** хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>3</sup>
- 9.1. Алданги оногдуулах хувь: **[moo]**
- Алдангийн нийт дүн: **[moo]**

- 
- 2 Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.
  - 3 Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүнгэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

**ЗАХИАЛАГЧ**

**НИЙЛҮҮЛЭГЧ**

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_ оны \_\_\_ сарын \_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_-наас \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл; Бусад шаардлагатай баримт бичиг<sup>5</sup>; Үнийн санал; Гэрээний тусгай нөхцөл; Гэрээний ерөнхий нөхцөл; Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь

Санхүүжилтийн хуваарь.

---

4 Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

5 Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.



Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*

*[Гарын үсэг]* \_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*

*[Утас/факсын*

*дугаар]*

*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*

*[Гарын үсэг]* \_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*

*[Утас/факсын*

*дугаар]*

*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*